




ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

Аудитын нэр: Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого,
түүний хэрэгжилт, үр дүн



**Хувь хүний орлогын албан татварын
хөнгөлөлт, чөлөөлөлтийн тайланг үнэн зөв
тайлагнаагүй байна.**

2017 он

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Аудитын менежер Г.Наранбаяр Ахлах аудитор Ц.Батсайхан Аудитор Б.Дарханбат 2017 оны 08 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70543156, 70543151 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: ГСА Сүмбэр сум 3-р баг, Нутгийн удирдлагын ордон 2 давхар 6 корпус , 208 тоот	Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Бүлэг 1 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх бодлогын баримт бичиг байхгүй, судалгаа шинжилгээний ажил хийгдээгүй байна. 1.1. Татварын ерөнхий газар нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар баримтлах бодлого боловсруулаагүй байна. 1.2 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг боловсронгуй болгох талаар судалгаа, шинжилгээний ажил хийгдээгүй байна. Бүлэг 2: Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тайланг олон нийтэд ил тод зарлаагүй, ТЕГ-аас хийгдсэн дотоод хяналт, шалгалтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. 2.1 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хяналт тавихдаа чиг үүрэг бүхий байгууллагууд харилцан уялдаатай ажиллаж, мэдээ тайлангаа хуулийн хугацаанд гаргасан байна. 2.1.1 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлэгч байгууллагууд мэдээ тайланг цаг хугацаандаа гаргасан байна. 2.1.2 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлэгч байгууллагууд мэдээлэл солилцох нэгдсэн мэдээллийн системгүй байна. 2.1.3 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогын хэрэгжилтийг хангуулахтай холбогдон гарсан санал хүсэлт байхгүй байна. 2.1.4 ААНОАТ, НӨАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар олон нийтэд ил тод мэдээлээгүй байна. 2.2. Орон нутгийн онцлогоос шалтгаалан зарим татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэгдээгүй байна.
--	---

	2.2.1 ААНОАТ, НӨАТ, ХХОАТ-ын тухай хуулиудын дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлсэн байна.
	2.2.2 Аймгийн Татварын хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хийх хяналт шалгалт төлөвлөгдөөгүй, мөн ТЕГ-аас хийгдсэн дотоод хяналт, шалгалтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
	Дүгнэлт:.....
	Зөвлөмж:.....
	Холбогдох байгууллагын санал.....
	Холбогдох байгууллагын саналд хийсэн тайлбар.....
	Хавсралтууд..... .

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/12 дугаар тушаалаар батлагдсан Үндэсний аудитын газрын ажлын төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий аудиторт Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөө, ҮАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

2. Аудитын зорилго, зорилт

Аймгийн Татварын хэлтсийн 2015-2016 оны Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд Гүйцэтгэлийн аудит хийж, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

3. Аудитын хамрах хүрээ

Аудитад аймгийн Татварын хэлтсээс 2015-2016 онд татварын хуулийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар баримталсан бодлого, хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн иргэн, аж ахуйн нэгжийн судалгаа, бүртгэл тайлагнал, анхан шатны баримт, холбогдох ажилтнуудтай хийсэн ярилцлага, бусад материалыг хамрууллаа.

4. Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ АДБОУС 3000-3100, Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, холбогдох бусад журмуудыг ашиглахаас гадна холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авч, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан, нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

5. Аудитын бүрэлдэхүүн:

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа, аудитын менежер Г.Наранбаяр нар хянан удирдаж, ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор Б.Дарханбат нар гүйцэтгэлээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл

Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн агуулгаар үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

6. Хүндрэл бэрхшээл

Аймгийн Татварын хэлтсийн татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн улсын байцаагч ээлжийн амралтаар явсан нь судалгаа, мэдээлэл удаашралтай гарах шалтгаан болсон.

7. Үндсэн мэдээлэл:

Татварын Ерөнхий хуулийн 3 дугаар зүйлд "... татвар бий болгох, өөрчлөх, чөлөөлөх, хөнгөлөх, ногдуулах, төлөхтэй холбогдсон харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулна." гэж заасны дагуу одоогийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 27 хуулийн нийт 265 хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалтууд байна. Орон нутгийн хэмжээнд дараахь хуулиудын холбогдох заалтуудаар хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлсэн байна. Үүнд:

Аймгийн Татварын хэлтсээс 2015-2016 онд 329,532.8 мянган төгрөгийн орлогыг НӨАТ-ын тухай хуульд заасны дагуу татвараас чөлөөлсөн байна. Үүнээс: тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.8-д заасны дагуу Хүнсний худалдаа, үйлчилгээ эрхэлдэг "Шивээ сервис" ХХК-д 170,078.0 мянган төгрөгийн, 13.5.9-т заасны дагуу "Буян гого" ХХК 60,502.2 мянган төгрөгийн, 13.14-т заасны дагуу Олон улсын төслийн байгууллагуудын худалдан авалтад 98,952.6 мянган төгрөгийн орлогыг НӨАТ-аас чөлөөлсөн байна.

Мөн 1 аж ахуйн нэгжид ААНОАТ-ын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1-т заасны дагуу 140.4 мянган төгрөгийн татварын хөнгөлөлт үзүүлсэн байна.

2015-2016 онуудад ХХОАТ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10, 16.1.12, 24 дүгээр зүйлийн 24.6-д заасны дагуу давхардсан тоогоор 936 иргэнд 491,062.1 мянган төгрөгийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлсэн байна. Үүнд: уг хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10-т заасны дагуу 12 иргэнд 7,146.7 мянган төгрөгийн, 16.1.12-т заасны дагуу давхардсан тоогоор 489 иргэнд 395,694.1 мянган төгрөгийн, 24 дүгээр зүйлийн 24.6-д заасны дагуу давхардсан тоогоор 435 иргэнд 88,221.3 мянган төгрөгийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлжээ.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх бодлого, зохицуулалт үр дүнтэй хэрэгжсэн эсэх

Бүлэг 1

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх бодлогын баримт бичиг байхгүй, судалгаа шинжилгээний ажил хийгдээгүй байна.

1.1 Татварын ерөнхий газар нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар баримтлах бодлого боловсруулаагүй байна.

Татварын ерөнхий газар нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх төрөөс баримтлах

бодлогыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна” гэсний дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулаагүй байна.

Орон нутгийн хэмжээнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар тусгайлан боловсруулсан бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг тухайн төрлийн татварын хуулийн хүрээнд ТЕГ-аас гаргасан журам, зааврын дагуу олгосон байна.

Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2015, 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогын талаар тусгагдаагүй байна.

Мөн Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод тулгуурласан Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого /2010-2021/-ын стратегийн зорилт 2-т “Татварын бааз суурийг бэхжүүлж татвар төлөгчдийн хүрээг өргөжүүлэх замаар орон нутгийн болон улсын төвлөрсөн төсвийн орлогыг жил бүр ханган биелүүлж, хөтөлбөрийн хугацаанд улсын төсвөөс татаасгүй, бие даасан аймаг байх нөхцлийг хангана”, Говьсүмбэр аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн дунд хугацааны зорилт 1.1.1-т “Татварын бодлогыг сурталчилах замаар татвар төлөгчдийн хүрээг өргөжүүлж, татварын бааз суурийг нэмэгдүүлнэ”, дунд хугацааны зорилт 5.51-т “Татварын бааз суурийг нэмэгдүүлж, татвар төлөгчдийн хүрээг өргөжүүлэх замаар орон нутгийн болон улсын төсвийн орлогыг ханган, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийн бууруулна.” гэж тус тус заасны дагуу ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэн ажилласан боловч эдгээр зорилтуудад татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар тусгагдаагүй байна.

Иймд Татварын ерөнхий газар нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д “Салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх төрөөс баримтлах бодлогыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна” гэж заасны дагуу Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах талаарх зөвлөмжийг ҮАГ-т уламжлахаар шийдвэрлэв.

1.2 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг боловсронгуй болгох талаар судалгаа, шинжилгээний ажил хийгдээгүй байна.

ТЕГ-аас нэгдсэн журмаар бодлогын баримт бичиг боловсруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Харин аймгийн Татварын хэлтсийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.4.1 стратегийн зорилтын 9 дэх заалтанд “Татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал өгөх, тооцоо судалгаа хийх, мэдээ гаргаж холбогдох байгууллага, алба тушаалтанд хүргүүлэх” гэж заасан боловч аймгийн Татварын хэлтсээс ГТЕГ-ын Татвар төлөгчдийг дэмжих газарт 2016 оны 02/258 дугаартай албан бичгээр “ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн заавар”-ын “4.1.11,

5.4 дэх заалтанд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг дэлгэрэнгүй тодорхой болгох” гэсэн санал хүргүүлсэн байна.

Энэ нь зөвхөн “ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн заавар”-т санал өгсөн бөгөөд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал хүргүүлээгүй, энэ талаар судалгаа шинжилгээний ажил хийгдээгүй байна.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд тавих
хяналтын тогтолцоо үр нөлөөтэй эсэх

Бүлэг 2

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тайланг олон нийтэд ил тод зарлаагүй, ТЕГ-аас хийгдсэн дотоод хяналт, шалгалтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.1 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хяналт тавихдаа чиг үүрэг бүхий байгууллагууд харилцан уялдаатай ажиллаж, мэдээ тайлангаа хуулийн хугацаанд гаргасан байна.

2015-2016 онд аймгийн хэмжээнд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн орлогын албан татварын тухай хуулиудын дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлэхдээ Гаалийн ерөнхий газар болон аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс сар бүр мэдээлэл авч хөндлөнгийн мэдээлэлд бүртгэх замаар харилцан уялдаатай ажиллаж ирсэн байна.

2.1.1 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлэгч байгууллагууд мэдээ тайланг цаг хугацаандаа гаргасан байна.

Аймгийн Татварын хэлтэс нь ААНОАТ-ын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т “Албан татвар төлөгч энэ хуулийн 21.3-т зааснаар хүргүүлсэн хуваарийн дагуу сар бүрийн 25-ны дотор албан татварыг урьдчилан төлж, татвар төлөлтийн улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд тушааж, албан татварын жилийн эцсийн тооцоо хийнэ.”, НӨАТ-ын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Албан татвар суутган төлөгч нь борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд ногдох албан татварыг доор дурдсан журмаар дараа сарын 10-ны өдрийн дотор төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлж, баталсан маягтын дагуу тайлангаа харьяалах татварын албанд тушаана”, ХХОАТ-ын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т “Энэ хуулийн 8.1.6, 11.1.6, 12.1.1, 12.1.2, 12.2, 13.1.1, 13.1.5, 14.1.2, 14.1.3, 15 дугаар зүйлд заасан орлогын албан татвар төлсөн тайланг хувь хүний орлогын албан татвар тодорхойлох тайлангийн хуудсаар гаргаж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор татварын албанд хүргүүлнэ.” гэж тус тус заасны дагуу ААНБ, иргэдээс татварын тайлан, мэдээг хүлээн авсан байна.

2015 оны ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн буцаан олголтын материалыг 2016 оны 03 сарын 11-нд, 2016 оны ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн буцаан олголтын материалыг 2017 оны 03 сарын 24-нд тус тус аймгийн СТСХ-т тус тус ирүүлсэн байна.

Тайланг хугацаанд нь тайлагнасан боловч аймгийн нэгдсэн санхүүгийн тайлангийн төсвийн гүйцэтгэлийн тайланд Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн

54.5-т “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.” 54.5.2-т “татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт хавсаргана” гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд дээрх заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.1.2. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлэгч байгууллагууд мэдээлэл солилцох нэгдсэн мэдээллийн системгүй байна.

Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Санхүү, төрийн сангийн хэлтэс зэрэг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлэгч байгууллагууд нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой мэдээлэл солилцох нэгдсэн систем байхгүй байна. Тухайлбал: Гаалийн ерөнхий газраас гаалийн мэдүүлэг, аймгийн СТСХ-ээс төсөвт байгууллагуудаас ААНБ-уудад шилжүүлсэн дүнгийн мэдээллийг сар бүрийн эцэст цаасаар хүлээн авч хөндлөнгийн мэдээлэл болгон “TRIPS” програмд уг мэдээллийг оруулан хадгалж байна.

2.1.3 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогын хэрэгжилтийг хангуулахтай холбогдон гарсан санал хүсэлт байхгүй байна.

2015-2016 онд аймгийн Татварын хэлтэст татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогын хэрэгжүүлэхтэй холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан санал хүсэлт, гомдол гараагүй байна.

2.1.4 ААНОАТ, НӨАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.

Аймгийн татварын хэлтэс нь ХХОАТ-ын татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн мэдээ тайланг Говьсүмбэр аймгийн Татварын хэлтсийн фейсбүүк хаяг, аймгийн NCH телевиз, www.gobisumber.mta.mn цахим хаягаар мэдээлсэн боловч Аж ахуй нэгжийн орлогын албан татвар, Нэмэгдсэн өртгийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.

2.2. Орон нутгийн онцлогоос шалтгаалан зарим татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэгдээгүй байна.

2.2.1 ААНОАТ, НӨАТ, ХХОАТ-ын тухай хуулиудын дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд 2015-2016 он ААНОАТ, НӨАТ, ХХОАТ-ын тухай хуулиудын хүрээнд 8 байгууллага, 936 иргэнд нийт 820,735.3 мянган төгрөгийн хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлсэн байна. Үүнд:

- ААНОАТ-ын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1-т “үр тариа, төмс, хүнсний ногоо;” бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн буюу тариалсан аж ахуйн нэгжийн зөвхөн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох албан татварыг 50 хувиар хөнгөлнө.” гэж заасны дагуу газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг “Эмээлийн хишиг хонд” ЗБН-д 140,4 мянган төгрөгийн татварын хөнгөлөлт эдлүүлсэн байна.
- НӨАТ-ын тухай хуульд заасны дагуу 7 байгууллагад нийт 329,532.9 мянган төгрөгийг татвараас чөлөөлсөн байна. Тухайлбал, НӨАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.8-д “орон сууцны зориулалтаар

баригдсан зориулалтын дагуу ашиглагдаж байгаа байрыг болон түүний тодорхой хэсгийг хөлслүүлэх үйлчилгээ,” гэж заасны дагуу Хүнсний худалдаа, үйлчилгээ эрхэлдэг “Шивээ-сервис” ХХК-д 170,078.0 мянга, 13.5.9-т “боловсролын болон мэргэжлийн сургалт явуулах тусгай зөвшөөрөлтэй хувь хүн, хуулийн этгээдийн эрхлэн гүйцэтгэж байгаа дүрэмд нь заасан боловсрол, мэргэжил олгох үйлчилгээ,” гэж заасны “Буян гого” ХХК цэцэрлэгт 60,502.2 мянга, 13.14-т “Монгол Улсын Засгийн газраас гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагатай байгуулж соёрхон баталсан олон улсын гэрээний дагуу санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээ,” гэж заасны дагуу Олон улсын төслийн байгууллагуудын худалдан авалтад 98,952.6 мянган төгрөгийн орлогыг тус тус НӨАТ-аас чөлөөлсөн байна.

2015-2016 онд НӨАТ-аас чөлөөлөгдсөн орлогын дүнг хуулийн заалт бүрээр хүснэгтээр харуулбал:

Хуулийн заалт	НӨАТ-аас чөлөөлөгдсөн орлогын дүн		Нийт дүн
	2016	2015	
13.5.8	16,223.0	153,855.0	170,078.0
13.5.9	35,124.7	25,377.5	60,502.2
13.14	98,952.6	0	98,952.6
Дүн	150,300.3	179,232.5	329,532.8

Хүснэгтээс харахад: 2015 оны НӨАТ-ын тухай хуулийн 13.5.8 заасны дагуу чөлөөлөгдсөн орлогын дүн 2016 онд 137,632.0 мянган төгрөг буюу 89.46%-иар буурахад “Шивээ-сервис” ХХК нь орон сууцнуудыг хувьчилсантай холбоотой байна. Тус хуулийн 13.14-т заасны дагуу чөлөөлөгдсөн орлогын дүн 2016 онд 98,952.6 мянга болсон нь Сангийн сайдын 2002 оны 113 дугаар тушаалаар батлагдсан “Буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламж хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр дотоодын зах зээлээс худалдан авсан бараа, ажил үйлчилгээг хуулийн дагуу нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхөд баримтлах журам” хүчингүй болж Сангийн сайдын 2016 оны 46 дугаар тушаалаар батлагдсан журмыг мөрдөж эхэлсэнтэй холбоотой байна.

НӨАТ-аас чөлөөлөгдсөн байгууллагуудад чөлөөлөлтийг эдлүүлэхдээ явцын хяналт тавилгүй зөвхөн тухайн байгууллагын ирүүлсэн татварын тайланд үндэслэсэн байна. Энэ нь НӨАТ-аас чөлөөлөгдөх үйл ажиллагаа бодитоор эрхлээгүй иргэн, ААНБ чөлөөлөлтөнд хамрагдаж болзошгүй нөхцөл байдал үүсгэж байгаа тул НӨАТ-ын тайланг хүлээн авахдаа татварын чөлөөлөлтөд хамруулахаар илгээсэн орлогын үнэн зөв эсэхэд явцын хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 12 сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолоор Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг 2015 онд 230,000.0 мянга, 2016 оны 12 сарын 05-ны өдрийн 07 дугаар тогтоолоор 2016 онд 250,000.0 мянган төгрөгөөр тус тус баталсан боловч буцаан олголтын гүйцэтгэлээр анх батлагдсан төсөвт тодотгол хийсэн байна.

- 2015-2016 онуудад ХХОАТ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10, 16.1.12, 24 дүгээр зүйлийн 24.6-т заасны дагуу давхардсан тоогоор 936 иргэнд 491,062.2 мянган төгрөгийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлсэн байна.

ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэхээр батлагдсан төсөв, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:


Он	Анх батлагдсан	Тодотгосон	Зөрүү
2015	230,000.0	222,267.4	7,732.6
2016	250,000.0	268,794.8	-18,794.8
Нийт	480,000.0	491,062.2	-11,062.2

Хүснэгтээс харахад: 2016 онд өмнөх оноос 20,000.0 мянган төгрөгөөр илүү батлуулсан боловч гүйцэтгэлээр 46,527.4 мянган төгрөгөөр өссөн байна.

ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт нь тухайн оны эдийн засгийн өсөлт, бууралт, зарим салбарын цалингийн хэмжээ, нэмэгдэл болон орон нутагт шинээр байр баригдах, засварлагдах зэрэг татварын албанаас үл хамаарах нөхцөл байдлуудтай холбоотой байдаг. Тухайлбал: 2015-2016 онд Шивээговь суманд Шивээ-Овоо ХК-д орон сууцны барилга шинээр ашиглалтад орсон, Сүмбэр суманд УБТЗ-ын шинэ орон сууц баригдаж, ашиглалтад орсон зэрэгтэй холбогдуулан ХХОАТ-ын хуулийн 16.1.12-д заасан чөлөөлөлтөнд хамрагдах иргэдийн тоо тухайн жилд өссөн, тухайн жилд уурхайн өндөр цалинтай иргэд хамрагдснаас хөнгөлөлт, чөлөөлөлтийн буцаан олгох үнийн дүн нэмэгдсэн байна.

Хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлсэн байдлыг хуулийн заалт тус бүрээр нь авч үзвэл дараах үзүүлэлттэй байна. Тухайлбал: ХХОАТ-ын 16 дугаар зүйлийн 16.1.10-т “хөгжлийн бэрхшээлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хувь хүний орлого,” гэж заасны дагуу 12 иргэнд 7,146.7 мянган төгрөгийн, 16.1.12-т “хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого.” гэж заасны дагуу давхардсан тоогоор 489 иргэнд 395,694.1 мянган төгрөгийн, 24 дүгээр зүйлийн 24.6-д “Албан татвар төлөгчийн төрсөн буюу үрчилсэн хүүхэд гадаад, дотоодын их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль, коллежид элсэн суралцаж байгаа бол түүний сургалтад төлсөн, баримтаар нотлогдож байгаа төлбөрийн хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ.” гэж заасны дагуу давхардсан тоогоор 435 иргэнд 88,221.3 мянган төгрөгийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлжээ.

2015-2016 онд ХХОАТ-ын тухай хуулиар буцаан олгосон татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг графикаар харуулбал



Графикаас харахад: Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12-д “хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30,000.0 мянган төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого” гэж заасны дагуу буцаан олгосон дүн өмнөх оноос 52,102.2 мянган төгрөг буюу 23%-иар өссөн бөгөөд үүнд орон сууцны ипотекийн зээлдэгчийн тоо улсын хэмжээнд өмнөх оноос 12,617 буюу 14%-иар өссөн нь нөлөөлсөн байна.

Орон нутагт Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль болон Онцгой албан татварын тухай хуулийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамаарах үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж байхгүй учраас уг хуулиудын хүрээнд хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэгдээгүй байна.

2015-2016 онд олгосон хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн буцаан олголтыг анхан шатны баримтын бүрдэл, тайлантай тулган баталгаажуулахад дараах зөрчил, дутагдлууд илэрлээ. Үүнд:

1. ХХОАТ-ын тайланд шууд бус орлого, нийгмийн даатгалын шимтгэл, татвар ногдуулах орлогыг буруу тодорхойлсны улмаас 2015 онд 58 иргэний 4,232.1 мянга, 2016 онд 32 иргэний 2,558.4 мянга, нийт 90 иргэний 6,790.5 мянган төгрөгөөр дараа онд татвараас чөлөөлөгдөх орлогын дүнг илүү тайлагнасан байна.
2. 2015 онд 11 иргэний 7,931.9 мянган төгрөгийн, 2016 онд 1 иргэний 728.2 мянган төгрөгийн нийт 8,660.1 мянган төгрөгийн 12 иргэний ХХОАТ-ын тайланг /ТТ-06А/ гаргаж баримтанд хавсаргаагүй байна.
3. 2015-2016 онд ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-т заасны дагуу 6 иргэнд олгосон 1,277.7 мянган төгрөгийн хөнгөлөлтөөс 408.5 мянган төгрөг нь анхан шатны баримтгүй болон анхан шатны баримтын дүнгээс илүү тооцож олгосон байна.

Эдгээр нь ТЕГ-ын даргын 2009 оны 11 сарын 20-ны өдрийн “Заавар, маягт батлах тухай” 523 дугаар тушаалын 5 дугаар зүйлийн 5.4-т “Татварын алба хуулийн 24 дүгээр зүйлийн 6-д заасан хөнгөлөлтийг эдлүүлэхдээ албан татвар төлөгчөөс ирүүлсэн дараах баримтыг үндэслэнэ.” 5.4.4-т “Эцэг, эхээс хүүхдийнхээ сургалтын төлбөр төлсөн тухай орлогын баримт”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Татварын алба Хуулийн 15.2 болон 16 дугаар зүйлд заасны дагуу албан татвараас чөлөөлөгдөх, 24.1, 24.5, 24.6, 25 дугаар зүйлд заасан албан татварын хөнгөлөлт эдлэх албан татвар төлөгчийг ТЕГ-ын даргын тушаалаар батлагдсан ... харъяалах татварын албанд тайлагнасан байдалд хяналт тавьж ажиллана.”, 6.4-т “Татварын алба нь албан татвар төлөгчийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн тооцоог хийхдээ хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх эрхтэйг нотолсон холбогдох баримтуудыг хөнгөлөлт, чөлөөлөлтийн тооцоонд бүрэн хавсаргасан эсэхийг нягтлан үзнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй 9,068.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлж, татвараас чөлөөлөгдөх орлогыг үнэн зөв бүртгэх, тайланг хянаж, баталгаажуулах, холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллах, дээрх алдаа зөрчлийг цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Мөн албан ажлаа зохих журмын дагуу гүйцэтгээгүй, хариуцсан ажилдаа хайнга хандсан, анхан шатны баримтанд үндэслэн татварын тайланг үнэн зөв тайлагнаагүй, шат шатны хяналтыг хэрэгжүүлээгүй татварын улсын байцаагч нарт хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.2.2 Аймгийн Татварын хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хийх хяналт шалгалт төлөвлөгдөөгүй, мөн ТЕГ-аас хийгдсэн дотоод хяналт, шалгалтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймгийн татварын хэлтэс нь 2015 онд 25 үзүүлэлтээр, 2016 онд 40 үзүүлэлтээр үйл ажиллагаагаа төлөвлөсөн боловч татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хяналт шалгалт явуулахаар төлөвлөгдөөгүй байна.

Иймд татвар төлөгчдийн илгээсэн тайланг хүлээн авахдаа явцын хяналтыг тухай бүр хэрэгжүүлж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

ГТЕГазрын дэд даргын 2016 оны 05 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан удирдамжаар ГТЕГазрын ХШҮДАГ-аас аймгийн Татварын хэлтэст 2016 оны 06 сарын 06-нд дотоод аудит хийгдсэн бөгөөд дээрх хяналт шалгалтаар илэрсэн 33 зөрчлийг арилгуулах зөвлөмж өгсөн байна.

Аймгийн Татварын хэлтэс дээрх шалгалтаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2016 оны 06 сарын 13-ны өдөр батлан, хэрэгжүүлэх арга хэмжээ авч 2016 оны 10 сарын 03-ны өдөр биелэлтийг тайлагнасан боловч зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна. Тухайлбал: 2015 оны ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн алдаатай хүлээн авсан тайланг завсарлах талаар зөвлөмж өгсөн боловч 90 иргэний тайланд шууд бус орлого, нийгмийн даатгалын шимтгэл, татвар ногдуулах орлого болон татвараас хөнгөлөх, чөлөөлөгдөх дүнг зөрүүтэй тусгасныг засварлаагүй байна.

Иймд дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах, биелэлтийг үнэн зөв тайлагнах талаар удирдлагын зүгээс анхаарч ажиллах шаардлагатай байна.

Аудитаар нийт 15,859.1 мянган төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлснээс 9,068.6 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 6,790.5 мянган төгрөгийн зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх бодлогын баримт бичиг байхгүй, судалгаа шинжилгээний ажил хийгдээгүй байна.
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан, НӨАТ-ын тайлангийн хөнгөлөлтийг эдлүүлэхдээ хяналт шалгалт хийлгүй, тухайн татвар төлөгчийн гаргасан тайланд үндэслэн хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлсэн байна
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тайланг олон нийтэд ил тод зарлаагүй, ТЕГ-аас хийгдсэн дотоод хяналт, шалгалтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлэгч байгууллагууд мэдээлэл солилцох нэгдсэн мэдээллийн системгүй байна.
- ХХОАТ-ын тайлангаар татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлэхдээ тайланг зөрүүтэй гаргаж, татварын тайланг хавсарган үдэж архивын нэгж болгоогүй байна.
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар хяналт шалгалт хийхээр үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Татварын хэлтсийн даргад:

- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх нэгдсэн бодлогын баримт бичигтэй болох, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход судалгаа шинжилгээний ажлыг хийж, холбогдох байгууллагад саналаа хүргүүлэх
- Аймгийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн төсвийн гүйцэтгэлийн тайланд Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.2-т “татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт хавсаргана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах
- ХХОАТ-ын тайлангаар татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлэхдээ тайланг хянаж хүлээн авах, үнэн зөв тайлагнаж, татварын тайланг хавсаргаж байх
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлэгч байгууллагууд мэдээлэл солилцох нэгдсэн мэдээллийн системтэй болох талаар холбогдох байгууллагад саналаа уламжилах
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар хяналт шалгалт хийхээр үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тайланд хийсэн дотоод аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, илэрсэн зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх.
- Аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилган албан шаардлага, зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг тайлагнах

ҮАГ-т уламжлах санал:

- Татварын ерөнхий газар нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д “Салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх төрөөс баримтлах бодлогыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна” гэж заасны дагуу Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ


**ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТЭС**
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Чойр: 3 дугаар баг,
Утас/Факс: (076) 7054 3185

2017 - 09 - 05 № 01/523
Танай _____ -ны № _____ -т

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Танай 2017 оны 09 сарын 01-ны өдрийн 164
тоотын хариуг хүргүүлж байна.
Хавсралт хуудастай

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ П.ЭНХ-ОЮУН

08 403

Documents/Documents/Word/Toot/A5 .do

Гүйцэтгэлийн аудитад өгөх тайлбар, хүсэлт

“Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан”-гаар илэрсэн зөрчлийн нэгтгэлд дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1. “94 иргэний ХХОАТ-ын тайланд шууд бус орлого болон НДШ, татвар ногдуулах орлогыг буруу тайлагнасны улмаас дараа оны хөнгөлөлт, чөлөөлөлд хамрагдах орлогын дүн зөрсөн” гэсэн нь хуулийн хувьд үндэслэлгүй юм.
Учир нь, ХХОАТ-ын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4-т “шууд бус орлогод ногдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр” ногдуулахаар зохицуулагдсан, түүнчлэн ЭМД, НДШ-ийг шууд бус орлогын нийт дүнгээс суутгадаг тул ХХОАТ-ын тайлангийн маягт /ТТ-06/-н 5 дугаар мөрөнд тухайн татвар төлөгч иргэний нийт орлогын дүнгээс суутгасан ЭМД, НДШ бичигдэж, шууд бус орлого нь 8 дугаар мөрөнд бичигдэхэд 82 дугаар мөрний дараа оны татвар ногдох орлогоос чөлөөлөгдөх орлогын дүнд нөлөөлөхгүй болно.
Мөн, ХХОАТ-ын тухай хуулийн дагуу татварын хөнгөлөлт чөлөөлөлд хамрагдаж буй иргэний цалингийн карт дахь тайлант хугацаанд суутгагдсан ХХОАТ-ын дүн нь тайлангийн маягт дахь 76 дугаар мөрний нийтлэг хувь хэмжээгээр бусдад суутгуулсан татвар гэсэн үзүүлэлтэд бичигддэг тул төсвөөс буцаан авах албан татварын хэмжээ ямар нэг байдлаар зөрүүгүй олгогддог болохыг харгалзаж үзнэ үү.
2. “13 иргэний хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн баримтанд ХХОАТ-ын тайлант хавсаргаагүй” гэсэн зөрчлийн хувьд 13 иргэний (2015 оны тайлан хэвлээгүй 12, 2016 оны тайлан хэвлээгүй 1) тайлан ирүүлээгүй жагсаалт Аудитын явцад гаргаж өгсөн бөгөөд эдгээр 13 иргэний ХХОАТ-ын тайлант гүйцэтгэлийн аудитын явцад цахим тайлангийн системд шивэгдсэн тайланг 12 иргэнээр хэвлүүлэн, тайланд гарын үсэг зуруулж, баталгаажуулан хавсаргасан бөгөөд 2015 оны тайлан хавсаргаагүй гэх 1 иргэн (П.Амармэнд) гадаадад зорчсон тул гарын үсэг зуруулаагүй байна. Иймд, дээрх зөрчлийн дүнг гарын үсэг зурагдаагүй 1 иргэний буцаан авах дүнгээр тооцон, бууруулж өгнө үү.
3. “Анхан шатны баримтын бүрдэлгүй олгосон татварын буцаан олголт” гэсэн зөрчилд холбогдох иргэдээс дутуу авсан баримтуудыг тайланг хянаж хүлээн ТУБ нараар 2017 оны 9 сарын 5-ны дотор нөхөн бүрдүүлүүлж, баримтад хавсаргаж, хариуг эргэн танилцуулах тул уг зөрчилд тавигдсан 408,5 мянган төгрөгийн актыг албан шаардлага болгож өгнө үү.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

Аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна.

Тайлбар 1:

Саналтай танилцаад 94 иргэний материалыг хянан үзээд 90 болгон өөрчлөлт оруулав.

Тайлбар 2:

Саналтай танилцаад 12 болгон өөрчлөлт оруулав.

Тайлбар 3:

Саналтай танилцаад 408.5 мянган төгрөгийг актын төлбөрөөс чөлөөлж, зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.